



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/100

Халбан

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 9.5 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/395 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүх охин тугал, охин хурга, ишгийг хамруулах ажлыг 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс 09 дүгээр сарын 12-ны хүртэл технологийн хугацаанд чанартай зохион байгуулж, хэрэгжүүлэхийг "Баялаг үйл-Ундрах" мал эмнэлгийн эзэн, малын эмч (М.Баатаржав), "Таг дүүрэн сүрэг" мал эмнэлгийн эзэн, малын эмч (Н.Доржжүгдэр) бусад малын эмч мэргэжилтнүүд, багийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Бруцеллэзын вакцинжуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын ажилд хяналт тавьж эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (Н.Алтанхуяг)-д үүрэг болгосугай.

4. Малчдыг тогтоосон хугацаанд нэг цэгт малаа бэлэн байлгах, хүн хүчний нөөцийг бүрдүүлэх, зарлан мэдээлэл хүргэх зэрэг шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг бүх багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР

